АККУРЭЙТ ФИНАНС АУДИТ ХХК

“МИЛЛЕННИУМ ФИНАНС ББСБ” ХХК

2020 оны 01-р сарын 01-ээс 12-р сарын 31-ний байдлаарх санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан, зөвлөмж.

Улаанбаатар хот
2021 он

АККУРЭЙТ ФИНАНС АУДИТ
Монгол улс, Улаанбаатар хот
Баянгол дүүрэг, Энхтайваны өргөн чөлөө,
4 дүгээр хороо, Тэнүүн апартмент 3-205 тоот
Утас: 70133743, 99995143, Факс: (976) 7013-3743
E-mail: acc.fin.audit@gmail.com
accuratefinance_audit@yahoo.com

2021.03.30 № А-26
танай_____-ны №_____-т

Аудит, нягтлан бодох бүртгэл,
санхүүгийн зөвлөгөөний
итгэмжлэгдсэн байгууллага

"Милленниум финанс ББСБ" ХХК-ийн
Захирал Р. Цолмон танаа

ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

Бид "Милленниум финанс ББСБ" ХХК-ийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон бэлтгэсэн санхүүгийн байдлын тайлан, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, эдгээр санхүүгийн тайлантай холбоотой нэмэлт тодруулга болон бусад тайлангуудад аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар "Милленниум финанс ББСБ" ХХК-ийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдлын тайлан, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлангууд нь бүхий л материалаг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын дагуу үнэн зөв илэрхийлэгдсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид аудитаа Аудитын олон улсын стандартын дагуу хийж гүйцэтгэсэн болно. Эдгээр стандартууд нь ёс зүйн шаардлагуудад нийцэж ажиллах, мөн санхүүгийн тайлангууд нь материаллаг алдаагүй эсэх талаар зохистой нотолгоо олж авахын тулд аудитаа төлөвлөж гүйцэтгэхийг биднээс шаарддаг.

Аудиторын үүрэг хариуцлага нь хийж гүйцэтгэсэн аудитад үндэслэн эдгээр санхүүгийн тайлангуудын талаар дүгнэлт гаргах юм.

Аудитын ажилд санхүүгийн тайлангийн дүн болон тодруулгуудын талаар аудитын нотолгоо олж авах горимуудыг гүйцэтгэх, түүвэр шалгалтын арга ашиглан магадлах ажил багтана.

Бидний олж авсан аудитын нотолгоо нь гаргасан дүгнэлтэнд хангалттай, зохистой үндэслэл болж чадсан гэдэгт итгэлтэй байна.

Аудитын гол асуудлууд

Санхүүгийн тайланд нөлөө үзүүлэхүйц материаллаг алдаа илрээгүй.

Санхүүгийн тайлантай холбоотой удирдлагын үүрэг хариуцлага

Санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын дагуу үнэн зөв толилуулах нь Удирдлагын үүрэг хариуцлага байдаг. Энэхүү хариуцлагад нягтлан бодох бүртгэлийн зохистой бодлогуудыг сонгон авч хэрэглэх, мөн нөхцөл байдалд уялдсан нягтлан бодох бүртгэлийн тооцооллуудыг хийх замаар залилан, алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх, толилуулах үйл явцад холбоотой дотоод хяналтыг бий болгох, хэрэгжүүлэх, тогтмол хэрэглэж байх үүрэг хариуцлагатай байна.

Аудиторын үүрэг хариуцлага

Бидний зорилго нь санхүүгийн тайлангууд нь бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв бөгөөд шударгаар толилуулагдсан эсэхийг үндэслэлтэй баталгаажуулж аудиторын дүгнэлтэнд тусгах явдал юм.

Бидний олж авсан үндэслэлтэй нотолгоо нь энэхүү гаргасан дүгнэлтэнд баталгаатай үндэслэл болж чадна гэдэгт итгэлтэй байгаа ч Аудитын Олон Улсын Стандартын дагуу хийж гүйцэтгэсэн аудит нь оршин байж болзошгүй залилан эсвэл алдааг бүрэн илэрхийлнэ гэсэн баталгаа биш юм.

АККУРЭЙТ ФИНАНС АУДИТ ХХК

ЗАХИРАЛ Ж.ОЮУНБИЛЭГ

АУДИТЛАГДСАН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

(төгрөгөөр)

БАЛАНСЫН ЗҮЙЛ	ТМ	2019.12.31	2020.12.31
1. ХӨРӨНГӨ			
1.1 Эргэлтийн хөрөнгө			
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	3	26,906,254.61	37,034,100.43
Зээл /цэврээр/	4	1,328,710,721.71	1,381,590,061.44
Бусад авлага	5	251,040,429.44	375,842,766.64
Бусад хөрөнгө	6	76,425,600.78	110,944,277.52
Эргэлтийн хөрөнгийн дүн		**1,683,083,006.54**	**1,905,411,206.03**
1.2 Эргэлтийн бус хөрөнгө			
Үндсэн хөрөнгө	7	128,742,791.21	139,020,301.47
Хуримтлагдсан элэгдэл	7	(26,258,642.77)	(38,347,372.06)
Биет бус хөрөнгө	7	4,809,415.68	4,291,309.29
Хуримтлагдсан элэгдэл		-	-
Эргэлтийн бус хөрөнгийн дүн		**107,293,564.12**	**104,964,238.70**
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН		**1,790,376,570.66**	**2,010,375,444.73**
2. ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ			
2.1 Өр төлбөр			
Цалингийн өглөг	8	1,887,908.21	190,070.05
Татвар, нийгмийн даатгалын өглөг	8	4,275,770.88	20,006,455.79
Бусад өглөг	8	89,902.85	8,719,697.68
Богино хугацаат өр төлбөрийн дүн		**6,253,581.94**	**28,916,223.52**
Урт хугацаат зээл		-	-
Урт хугацаат өр төлбөрийн дүн		**-**	**-**
Өр төлбөрийн нийт дүн		**6,253,581.94**	**28,916,223.52**
2.2 Эздийн өмч			
Энгийн хувьцаа	9	1,751,050,000.00	1,751,050,000.00
Нэмж төлөгдсөн капитал		-	-
Хувьцаат капиталын дүн		**1,751,050,000.00**	**1,751,050,000.00**
Хуримтлагдсан ашиг, (алдагдал)		**33,072,988.72**	**230,409,221.21**
Тайлант үеийн	9	31,511,264.42	197,336,232.49
Өмнөх үеийн		1,561,724.30	33,072,988.72
Эздийн өмчийн дүн		**1,784,122,988.72**	**1,981,459,221.21**
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН		**1,790,376,570.66**	**2,010,375,444.73**
		-	-

Нэмэлт тодотголууд нь эдгээр санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

АУДИТЛАГДСАН ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

(төгрөгөөр)

	ҮЗҮҮЛЭЛТ	2019.12.31	2020.12.31
1	Хүүгийн орлого	462,534,415.84	489,424,945.54
2	Хүүгийн зардал	-	-
Цэвэр хүүгийн орлого		**462,534,415.84**	**489,424,945.54**
3	Хүүгийн бус орлого	13,745,653.68	4,188,292.37
4	Хүүгийн бус зардал	(238,154,616.67)	(261,477,871.54)
Цэвэр хүүгийн бус орлого		**(224,408,962.99)**	**(257,289,579.17)**
5	Болзошгүй эрсдлийн сан байгуулахаас өмнөх үйл ажиллагааны ашиг / алдагдал	238,125,452.85	232,135,366.37
6	Болзошгүй эрсдлийн зардал	(194,253,481.11)	(872,719.96)
Үндсэн үйл ажиллагааны ашиг, /алдагдал/		**43,871,971.74**	**231,262,646.41**
7	Үндсэн бус үйл ажиллагааны орлого	-	-
8	Үндсэн бус үйл ажиллагааны зардал	(7,973,510.15)	(33,848,860.00)
Ердийн үйл ажиллагааны ашиг / алдагдал		**35,898,461.59**	**197,413,786.41**
9	Ердийн бус орлого	-	-
10	Ердийн бус зардал	-	-
Татвар төлөхийн өмнөх ашиг /алдагдал		**35,898,461.59**	**197,413,786.41**
Орлогын татварын зардал		**(4,387,197.17)**	**(77,553.92)**
Цэвэр ашиг		**31,511,264.42**	**197,336,232.49**

Нэмэлт тодотголууд нь эдгээр санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

АУДИТЛАГДСАН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

(төгрөгөөр)

ҮЗҮҮЛЭЛТ	Хувьцаат капитал	Нэмж төлөгдсөн капитал	Хуримтлагдсан ашиг, алдагдал	Нийт дүн
2018 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	**1,010,000,000.00**	**606,050,000.00**	**151,561,724.31**	**1,767,611,724.31**
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Залруулсан үлдэгдэл	606,050,000.00	(606,050,000.00)	-	-
Дахин үнэлгээний зөрүү	-	-	-	-
Тайлант оны ашиг, (алдагдал)	-	-	31,511,264.42	**31,511,264.42**
Ногдол ашиг	135,000,000.00	-	(150,000,000.00)	**(15,000,000.00)**
Өмчид гаргасан өөрчлөлт	-	-	-	-
2019 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	**1,751,050,000.00**	-	**33,072,988.73**	**1,784,122,988.73**
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Залруулсан үлдэгдэл	-	-	-	-
Дахин үнэлгээний зөрүү	-	-	-	-
Тайлант оны ашиг, (алдагдал)	-	-	197,336,232.49	**197,336,232.49**
Ногдол ашиг	-	-	-	-
Өмчид гаргасан өөрчлөлт	-	-	-	-
2020 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	**1,751,050,000.00**	-	**230,409,221.22**	**1,981,459,221.22**

АУДИТЛАГДСАН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

(төгрөгөөр)

ҮЗҮҮЛЭЛТ	**2019.12.31**	**2020.12.31**
1. Үндсэн үйл ажиллагааны мөнгөн орлого	1,340,656,753.72	1,272,889,587.43
2. Үндсэн үйл ажиллагааны мөнгөн зардал	1,924,839,392.65	1,228,912,881.61
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	**(584,182,638.93)**	**43,976,705.82**
3. Үндсэн бус үйл ажиллагааны мөнгөн орлого	-	-
4. Үндсэн бус үйл ажиллагааны мөнгөн зардал	7,973,510.15	33,848,860.00
Үндсэн бус үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	**(7,973,510.15)**	**(33,848,860.00)**
Нийт цэвэр мөнгөн гүйлгээний дүн	**(592,156,149.08)**	**10,127,845.82**
5. МӨНГӨН ХӨРӨНГИЙН ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	**619,062,403.69**	**26,906,254.61**
6. МӨНГӨН ХӨРӨНГИЙН ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ	**26,906,254.61**	**37,034,100.43**
	-	(0.00)

Нэмэлт тодотголууд нь эдгээр санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

ТОДОТГОЛ 1 - ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

А Компанийн үүсэл гарал

"Милленниум финанс ББСБ" ХХК нь Улсын бүртгэлийн 9015002008, регистрийн 5297498 тоот дугаартай, 810,000.00 мянган төгрөгийн эздийн өмчтэй, 1 гишүүнтэйгээр байгуулагдсан. 2019 оны 05 сарын 06 өдөр өөрийн хөрөнгийн хэмжээгээ нэмэгдүүлж 1,751,050.00 мянган төгрөг болгон нэмэыгдүүлж улсын бүртгэлийн гэрчилгээндээ өөрчлөлт оруулсан.

2016 онд "Зээл" чиглэлээр үйл ажиллагаа явуулахаар байгуулагдсан.

1. Байгууллагын бүтэц, зохион байгуулалт

"Милленниум финанс ББСБ" ХХК нь захирал, нягтлан бодогч нийт 7 ажилтантайгаар үйл ажиллагаагаа явуулж байна

"Милленниум финанс ББСБ" ХХК нь 2008 онд Монгол улсын татварын албанд бүртгэгдсэн.

"Милленниум финанс ББСБ" ХХК-ийн албан ёсны хаяг: Улаанбаатар хот, СБД, 1-р хороо, ЧӨЧ 17, Гэрэгэ тауэр 701 тоотод байрлаж байна.

Утас,факс: Гар утас: 976-336677 Утас: 976-99112177

ТОДОТГОЛ 2 - НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГО

а. Санхүүгийн тайлагналын суурь

"Милленниум финанс ББСБ" ХХК -ийн удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-ын дагуу түүхэн өртгийн зарчмаар аккруэль сууриар бэлтгэгдсэн байна.

"Милленниум финанс ББСБ" ХХК нь нягтлан бодох бүртгэлээ Монгол төгрөгөөр бүртгэдэг ба гадаад валютаар гарсан ажил гүйлгээг зөвшөөрөгдсөн аргаар төгрөгт шилжүүлж бүртгэдэг. Нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа бодлого, зарчим нь Монгол улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, бусад хууль, тогтоомж аргачлал зааврын дагуу явагдаж байна.

б. Санхүүгийн тайланг бэлтгэсэн байдал

"Милленниум финанс ББСБ" ХХК нь нягтлан бодох бүртгэлээ санхүүгийн программ дээр хөтлөж байгаа болно.

Санхүүгийн тайлан нь Санхүүгийн байдлын тайлан, Орлогын дэлгэрэнгүй тайлан, Өмчийн өөрчлөлтийн тайлан, Мөнгөн гүйлгээний тайлан гэсэн үндсэн 4 тайлан, нягтлан бодох бүртгэлийн бодлого ба нэмэлт тодруулгаас бүрдсэн байна.

в. Тасралтгүй үйл ажиллагааны зарчим

"Милленниум финанс ББСБ" ХХК нь үйл ажиллагаагаа хэвийн үргэлжлүүлнэ гэсэн төсөөлөлд үндэслэн, тасралтгүй үйл ажиллагааны зарчмаар санхүүгийн тайлангаа бэлтгэдэг. Тус байгууллагыг татан буулгах, үйл ажиллагааг зогсоох бодит сонголт байгаагаас бусад тохиолдолд хэрэгжинэ.

г. Санхүүгийн хэрэгслүүд

Санхүүгийн хөрөнгө болон санхүүгийн өр төлбөр нь балансад мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө, дансны авлага, өглөг, зээлээс бүрдэнэ.

д. Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө

Компанийн хувьд мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө нь бэлэн мөнгө болон банкин дахь төгрөг, валютаас бүрддэг. Мөнгөн хөрөнгийг нэрлэсэн үнээр нь бүртгэлд тусгадаг.

е. Авлага

Авлагыг үүссэн нэрлэсэн үнээр бүртгэдэг. Авлагадаа найдваргүй авлагын нөөц сан байгуулаагүй.

ё. Бараа материал

Бараа материалын бүртгэлээ "БМ-ын байнгын систем"-ээр хөтөлдөг ба бараа материалын өртөг, зардлыг татварын хуулийн дагуу "Эхэлж авсанаа эхэлж зарлагадах арга"-аар тооцдог.

ж. Үндсэн хөрөнгө

Өртөг. *Үндсэн хөрөнгө нь хуримтлагдсан элэгдэл хассан цэвэр дүнгээр тайлагнагдсан. Үндсэн хөрөнгийн анхны өртөг нь худалдан авсан үнэ, тухайн хөрөнгийг зориулалтын байршил, нөхцөлд ашиглалтанд оруулахтай холбогдсон бусад зардлаас бүрдэнэ.*

Элэгдэл. *Үндсэн хөрөнгийн элэгдлийг ашиглагдах хугацааны туршид шулуун шугамын аргаар элэгдүүлдэг.*

з. Орлого

Орлого нь хүлээн авсан, эсвэл авахаар хүлээгдэж буй бодит үнэ цэнээр хэмжигдэнэ.

и. Өртөг, зардал

Нийт үйл ажиллагааны зардал нь үйл ажиллагааны /борлуулалтын болон удирдлагын/ зардал, үйл ажиллагааны бус зардал гэсэн 2 категориос бүрддэг.
Үйл ажиллагааны зардал нь ажиллагсадын цалин, нийгмийн даатгалын зардал, бичиг хэрэг, шуудан холбоо, төслийн зардал, тулш шатахуун, үндсэн хөрөнгийн элэгдэл, ашиглалтын болон засвар үйлчилгээний зардал, бусад зардлуудаас бүрдэнэ.
Үйл ажиллагааны бус зардал нь валютын ханшийн өөрчлөлтийн алдагдал, хүү торгуулийн зардлаас бүрдэнэ.

й. Татвар

Ажиллагсадаас авах Хувь Хүний Орлогын Албан Татварыг хуульд заасны дагуу сар бүр суутган авч, татварын байгууллагатайгаа тооцоо хийдэг. Мөн бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээнд ногдох бусад татварыг суутган тооцоо хийдэг.

к. Нийгмийн даатгалын шимтгэл

Байгууллага нь хуулийн дагуу эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын шимтгэлийг тооцож, тухайн жилийн зардалд хүлээн зөвшөөрдөг.

ТОДОТГОЛ 3– МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ

	2019.12.31	2020.12.31
Бэлэн мөнгө	-	-
Банкин дахь мөнгө	26 906 254,61	37 034 100,43
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн дүн	**26 906 254,61**	**37 034 100,43**

ТОДОТГОЛ 4–ЗЭЭЛ

	2019.12.31	2020.12.31
Зээл	1 563 302 572,49	1 571 190 262,15
(Зээлийн эрсдлийн сан)	(234 591 850,78)	(189 600 200,71)
Нийт дүн	**1 328 710 721,71**	**1 381 590 061,44**

ТОДОТГОЛ 5- БУСАД АВЛАГА

	2019.12.31	2020.12.31
Бусад авлага	24 976 909,42	6 159 160,70
Хуримтлуулж тооцсон хүүгийн авлага	226 063 520,02	369 683 605,94
Нийт дүн	**251 040 429,44**	**375 842 766,64**

ТОДОТГОЛ 6- БУСАД ХӨРӨНГӨ

	2019.12.31	2020.12.31
Урьдчилж төлсөн зардал, тооцоо	71,986,604.59	106,121,552.62
Материал, үнэ бүхий зүйл	2,422,232.00	2,423,565.19
Бусад	2,016,764.19	2,399,159.71
Нийт дүн	**76,425,600.78**	**110,944,277.52**

ТОДОТГОЛ 7–ҮНДСЭН ХӨРӨНГӨ

	Эд хогшил	Техник хэрэгсэл	Биет бус хөрөнгө	Нийт дүн
Өртөг				
2019 оны 12 сарын 31	91,402,146.21	37,340,645.00	4,809,415.68	133,552,206.89
Тайлант жилд нэмэгдсэн	69,110.26	10,208,400.00	-	10,277,510.26
Хасагдсан	-	-	-	-
2020 оны 12 сарын 31	**91,471,256.47**	**47,549,045.00**	**4,809,415.68**	**143,829,717.15**
Хуримтлагдсан элэгдэл				
2019 оны 12 сарын 31	(21,075,772.04)	(5,182,870.73)	-	(26,258,642.77)
Тайлант жилд нэмэгдсэн	(5,363,863.83)	(6,724,865.46)	(518,106.39)	(12,606,835.68)
Хасагдсан	-	-	-	-
2020 оны 12 сарын 31	(26,439,635.87)	(11,907,736.19)	(518,106.39)	(38,865,478.45)
Дансны цэвэр үнэ	**65,031,620.60**	**35,641,308.81**	**4,291,309.29**	**104,964,238.70**

ТОДОТГОЛ 8–ӨР ТӨЛБӨР

	2019.12.31	2020.12.31
Цалингийн өглөг	1,887,908.21	190,070.05
НДШ-ийн өглөг	-	1,595.44
ХХОАТ-ын өглөг	107,844.66	-
ОАТ-ын өглөг	4,167,926.22	20,004,860.35
Бусад өглөг	89,902.85	8,719,697.68
Өр төлбөрийн дүн	**6,253,581.94**	**28,916,223.52**

ТОДОТГОЛ 9-ЭЗДИЙН ӨМЧ

	2019.12.31	2020.12.31
Энгийн хувьцаа	1,751,050,000.00	1,751,050,000.00
Нэмж төлөгдсөн капитал	-	-
Хуримтлагдсан ашиг:	33,072,988.72	230,409,221.21
Эздийн өмчийн дүн	**1,784,122,988.72**	**1,981,459,221.21**

ТОДОТГОЛ 10–ОРЛОГО

	2019.12.31	2020.12.31
Хүүгийн орлого	**462,534,415.84**	**489,424,945.54**
Хугацаандаа байгаа зээлийн хүүгийн орлого	454,483,035.05	487,143,771.58
Хугацаа хэтэрсэн зээлийн хүүгийн орлого	7,497,933.96	3,147,442.91
Банкин дахь харилцах дансны хүүгийн орлого	553,446.83	775,539.23
Хүүгийн орлогын буцаалт	-	(1,641,808.18)
Хүүгийн бус орлого	**13,745,653.68**	**4,188,292.37**
Гадаад валютын ханшийн тэгштгэлийн орлого	5,868,712.61	62,092.37
Бусад орлого	7,876,941.07	4,126,200.00
Нийт дүн	**476,280,069.52**	**493,613,237.91**

ТОДОТГОЛ 11– ХҮҮГИЙН БУС ЗАРДАЛ, БОЛЗОШГҮЙ ЭРСДЛИЙН ЗАРДАЛ

	2019.12.31		2020.12.31
Хүүгийн бус зардал	**238 154 616,67**		**261 477 871,54**
Гадаад валютын ханшийн тэгштгэлийн зардал	6 259 702,67		-
Үндсэн болон нэмэгдэл цалин	125 245 349,89		153 487 898,15
НД, эрүүл мэндийн даатгалын шимтгэл	15 950 974,89		9 154 794,94
Албан томилолтын зардал	-		-
Сургалтын зардал	893 000,00		1 834 300,00
Зээл болон түүнтэй холбоотой авлагыг барагдуулах	221 624,00		-
Мэргэжлийн үйлчилгээний төлбөр	854 600,00		1 510 670,06
Даатгал	-		351 600,00
Түрээсийн төлбөр	39 335 900,00		44 043 573,00
Ашиглалтын зардал	5 138 230,00		5 432 415,00
Элэгдэл, хорогдолын зардал	6 561 362,87		12 911 724,42
Харуул хамгаалалтын зардал	1 429 500,00		1 232 000,00
Харилцаа холбоо, интернетын зардал	9 454 135,32		13 109 973,33
Шатахуун, тээврийн зардал	1 934 369,25		531 280,99
Сэлбэг хэрэгсэл, засвар үйлчилгээ	3 952 048,90		8 503 640,00
Зохицуулалтын хураамжийн зардал	2 580 000,00		2 850 000,00
Автоматжуулалттай холбоотой урсгал зардал	291 400,00		500 000,00
Зар сурталчилгаа, маркетингийн судалгаа	666 300,00		918 652,00
Бичиг хэргийн зардал	1 419 501,00		2 028 100,00
Ариун цэврийн зардал	2 988 740,00		2 360 374,00
Харилцагчдын сургалт судалгааны зардал	455 400,00		522 700,00
Бусад зардал	12 522 477,88		194 175,65
Болзошгүй эрсдлийн зардал	**194 253 481,11**		**872 719,96**
НИЙТ ДҮН	**432 408 097,78**		**262 350 591,50**

ТОДОТГОЛ 12– ҮНДСЭН БУС ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ

	2019.12.31		2020.12.31
Зочин төлөөлөгчийн зардал	459,349.13		141,100.00
Баяр ёслол	7,275,680.77		1,977,760.00
Бусад	238,480.25		31,730,000.00
Нийт дүн	**7,973,510.15**		**33,848,860.00**

Менежментийн захидал

"Аккурэйт финанс Аудит" ХХК аудитын явцад илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг "Милленниум финанс ББСБ" ХХК-ийн удирдлагад зориулж бэлтгэсэн, горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмжийг өглөө.

Энэхүү менежментийн захидлын агуулга АОУС-ын дагуу хийгддэг аудитын байгууллагын аудитын горимоос урган гарсан болно. Бидний хэрэгжүүлсэн горим, сорил нь санхүүгийн тайлангийн санал дүгнэлт гаргахад зориулагдсан.

Тиймээс аудитын зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаархи бидний үнэлэлт, дүгнэлтийг тусгаж байгаа болно.

"Аккурэйт финанс Аудит" ХХК нь та бүхний бүртгэл, тайлагнал, хяналтын үйл ажиллагааг сайжруулах зорилготой бөгөөд харин зөвлөмжийг хүлээн авч хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан "Милленниум финанс ББСБ" ХХК-ийн санхүүгийн холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Менежментийн захидалд дурдсан зөвлөмжүүд цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг ач холбогдлынх нь дарааллаар эрэмбэлэн дор нэгтгэн харуулав.

АУДИТОРЫН ЗӨВЛӨМЖ

- *Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 13.1.4 буюу " бараа, ажил, үйлчилгээний зардал Татварын ерөнхий хуулийн 28.5-д заасан дахин давтагдахгүй дугаар бүхий төлбөрийн баримт, импортын барааны татвар ногдуулж, гаалийн байгууллагад төлсөн тухай баримтаар баталгаажсан байх" гэсэн заалтыг мөрдөн ажиллах,*

- *Татварын өглөгийг цаг хугацаанд нь төлж барагдуулж байх нь хэрэгтэй. Монгол Улсын Татварын Ерөнхий хуулийн 74.2-т зааснаар " ... төлөгдөөгүй татварын дүнд хугацаа хэтэрсэн хоног тутамд 0.1 хувьтай тэнцэх хэмжээний торгууль ноогдуулах ..." хариуцлага хүлээх эрсдэлтэй,*

- *Монгол Улсын Нийгмийн даатгалын тухай хуулийн 20.2-т зааснаар " ... дутуу төлөгдсөн буюу хугацаандаа төлөгдөөгүй шимтгэлийг нөхөн төлүүлж, шимтгэлийн дүнгээс хугацаа хэтрүүлсэн хоног тутамд 0,3 хувийн алданги ногдуулна. Энэхүү алдангийн хэмжээ нь төлбөл зохих шимтгэлийн 50 хувиас хэтрэхгүй байх ..." хариуцлага хүлээх эрсдэлтэй,*

- *Мөнгөн гүйлгээний тайланг программ алдаатай илэрхийлдэг тул анхаарч ажиллах,*

Нягтлан бодох бүртгэлийн бодлого, зохион байгуулалт, үйл ажиллагаа, менежмент, хууль, тогтоол, заавар, журмыг хэрэгжүүлэх талаар та бүхний хийж буй ажлыг улам сайжруулахын тулд бидний өгч буй зөвлөмжүүдийг хэрэгжүүлэхэд анхаарч ажиллана гэдэгт итгэж байна.

Довчин САЙНБАЯР
МОНГОЛ УЛСЫН ЧИНЭЭЛСЭН НЯГТЛАН БОДОГЧ
13123182

АУДИТОР ***Д.САЙНБАЯР***
(Монгол улсын мэргэшсэн нягтлан бодогч,аудитор, БУМ)

Accurate finance Audit Хуудас № 11